

Давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шийдвэрийн бүтэц: Эрүүгийн хэрэг

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ДЭРГЭДЭХ
ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА,
МЭДЭЭЛЛИЙН АКАДЕМИ*

- I. Харьцуулсан судалгаа
 1. Америкийн Нэгдсэн Улс
 2. Бүгд Найрамдах Итали Улс
 3. Бүгд Найрамдах Солонгос Улс
 4. Бүгд Найрамдах Франц Улс
- II. Дүгнэлт

* Энэхүү судалгааг Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн Шүүхийн судалгааны төвийн дарга, хууль зүйн доктор Б.Дөлгөөн (Ph.D) удирдаж, Эрүүгийн эрх зүйн секторын эрхлэгч Э.Баасанбямба, судлаач П.Эрхэмбаяр, Б.Оюунзаяа, Ц.Баасанцэрэн, Б.Намуунзул болон Үндсэн хуулийн болон олон улсын эрх зүйн секторын судлаач С.Лувсандолгорхулан нар хийж гүйцэтгэв.



Хураангуй: Энэхүү судалгааны хүрээнд жишгийн болон эх газрын эрх зүйн бүлд хамаарах гадаадын зарим улсад эрүүгийн хэргийн давж заалдах болон хяналтын шатны шүүхийн эрх хэмжээ, шүүхээс гаргаж буй шүүхийн шийдвэрийн бүтэц, шийдвэрийг бичихэд баримтлах аргачлалын талаар харьцуулан судлав.

Жишгийн эрх зүйн бүлд давж заалдах шатны шүүхийн хяналтын хүрээ харьцангуй хязгаарлагдмал бөгөөд голчлон хууль хэрэглээний алдааг засах, шударга бус шийдвэрээс урьдчилан сэргийлэхэд чиглэдэг байна. Харин эх газрын эрх зүйн тогтолцоонд давж заалдах шатны шүүхийг анхан шатны шүүхийн шийдвэрийг өргөн хүрээнд хянах боломжтой бөгөөд хэргийн бодит байдлыг дахин үнэлэх, нотлох баримтыг шинээр судлах, хууль хэрэглээний алдааг засах замаар үнэн зөвийг тогтоох зорилгод илүү чиглэдэг гэж үзэх хандлагатай байна.

Давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шийдвэрийн бүтцийг судлан үзвэл, жишгийн эрх зүйн бүлд хамаарах улсуудад давж заалдах болон хяналтын шатны шүүхээс гаргаж буй шийдвэрийн бүтцийг хууль тогтоомжид нарийвчлан заагаагүй, харин шүүхийн дүрэм болон жишиг шийдвэрүүдийн бүтцийг баримталдаг байна. Харин эх газрын бүлд хамаарах улс орнуудад давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шийдвэрийн бүтцийн талаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд ерөнхий байдлаар хуульчилсан байна.

Харьцуулсан судалгааны хүрээнд жишгийн эрх зүйн бүлийг төлөөлүүлэн Америкийн Нэгдсэн Улсыг сонгов. Эх газрын эрх зүйн бүлийг төлөөлүүлэн Бүгд Найрамдах Итали Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Франц Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улыг тус тус сонгон судлав.

Түлхүүр үг: Шүүхийн шийдвэрийн бүтэц, шүүхийн эрх хэмжээ, үндэслэл бүхий шийдвэр, нотлох баримтыг дахин үнэлэх,

I. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

1. Америкийн Нэгдсэн Улс

Эрүүгийн хэргийн шүүхийн тогтолцоо нь Холбооны түвшинд 3 үндсэн шатлалтай.¹ Үүнд, анхан шатны шүүх (англ. *United States district court*), давж заалдах шатны шүүх (англ. *United States court of Appeals*), дээд шүүх (англ. *Supreme court of United States*) хамаарна.

1.1. Давж заалдах шатны шүүх

Холбооны давж заалдах шатны шүүх нь анхан шатны шүүхийн шийдвэрийг хянахдаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа шударга явагдсан эсэх, холбогдох хуулийг зөв хэрэглэсэн эсэхэд дүгнэлт өгнө. Эрүүгийн хариуцлага оногдуулсан байдал, хуулийг ноцтой зөрчсөн эсэхэд давж заалдах шатны шүүхээс хяналт тавих асуудлыг АНУ-ын эрх зүйн онолд дараах гурван үндсэн хэлбэрээр ангилан тайлбарладаг.²

¹ United states courts, "About U.S. District Courts", <https://www.uscourts.gov/about-federal-courts/court-role-and-structure/about-us-district-courts>, (last visited Mar.11, 2026).

² U.S. Court.go, data store, https://cdn.ca9.uscourts.gov/datastore/uploads/guides/stand_of_review/1.%20Definitions%202022.pdf, 2-16 дахь тал.



1. Хууль зүйн асуулт (англ. *questions of law*) буюу "De Novo" хяналт

Энэ нь давж заалдах шатны шүүх хэргийг анхан шатны шүүхтэй адил түвшинд бие даан дахин дүгнэн шийдвэрлэхийг хэлнэ. Өөрөөр хэлбэл, анхан шатны шүүхийн гаргаж буй шийдвэрийг бүхэлд нь орхиж тухайн асуудлыг шинээр үнэлж шийдвэрлэх хяналтын хэлбэр юм.

2. Фактад суурилсан асуулт (англ. *questions of fact*) "Clear error" хяналт

Давж заалдах шатны шүүх энэ тохиолдолд анхан шатны шүүх хэргийн бодит байдал (англ. *fact*)-д үнэлэлт дүгнэлт хийхэд алдаа гарсан эсэхийг хянаана. Харин нотлох баримтыг дахин үнэлж, хэргийн бодит байдлыг шинээр тогтоох эрхгүй бөгөөд зөвхөн тодорхой, илт алдаа байгаа эсэхэд үнэлэлт хийнэ.

3. Шүүгч хувийн үзэмжээр хэргийг шийдвэрлэсэн эсэх (англ. *matters of discretion*)³ "Abuse of discretion" хяналт

Энэ хяналтын хүрээнд анхан шатны шүүхийн шийдвэр нь нотлох баримтаар үндэслэгдээгүй, хуулийг буруу ойлгож хэрэглэсэн, эсхүл логик үндэслэлгүй шийдвэр гарсан эсэхийг хянаана. Өөрөөр хэлбэл, шүүхийн шийдвэр шүүгчийн үзэмжийн хүрээнээс хэтэрч, үндэслэлгүй байдлаар гарсан эсэхэд хяналт тавихыг ойлгоно.

Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн бүтэц

Холбооны эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр нь хуульд заасан албан ёсны шаардлагаар бус, харин Давж заалдах шатны шүүхийн журам (англ. *FRAP*) болон шүүхийн практикт тогтсон стандартын дагуу бичигддэг. Энэхүү стандарт нь шүүх шийдвэрийг ойлгомжтой, системтэй, маргаан үүсгэхгүйгээр хэргийн оролцогчид болон иргэдэд хүргэх зорилготой байна.

Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн бүтэц нь нийтлэг дараах байдлаар бичигдэж байна.

1. Background-Хэргийн түүх, хэргийн нөхцөл байдал

Энэ хэсэгт тухайн хэргийг анхан шатны шүүхэд хэрхэн шийдвэрлэсэн талаар мөн хэргийн үйл баримт, шүүгдэгчийг ямар хуулийн зүйл заалтаар буруутгаж байгаа талаар тодорхой бичнэ. Үүнийг илүү дэлгэрэнгүй байдлаар 3 ангилалд хувааж болно.

а) Factual History- Үйл явдал, нотлох баримт, шүүгдэгчийн гэм буруутай үйлдэл, гэрчийн мэдүүлэг зэргийг товч тодорхой, баримтад суурилж бичнэ.

б) Legal Background- Шийдвэрлэгдэж буй хэрэгтэй холбоотой хууль, эрх зүйн зохицуулалт, өмнө шийдвэрлэгдсэн жишиг шүүхийн шийдвэрүүдийн товч тоймлоно.

в) Procedural history- Хэрэг анхан шатны шүүхэд хэрхэн шийдэгдсэн, давж заалдах шатанд ямар үндэслэлээр гомдол гаргасан зэргийг энэ хэсэгт оруулна.

2. Discussion- Хэлэлцэх асуудал

Энэ хэсэг нь анхан шатны шүүхийн шийдвэрийг үнэлэх, маргаантай асуудлыг шийдвэрлэх үндсэн хэсэг юм. Үүнд:

³ Содовсүрэнгийн Нарангэрэл, Хууль зүйн толь бичиг, 2012, (УБ хот, Admon хэвлэл)-д тус агуулгыг "Хувийн үзэмжээс шалтгаалсан", "Өөрийн үзэмжийн дагуу ажилласан" гэж орчуулсан байна. 209 дахь тал.



a) Standard of Review- Давж заалдах шүүх ямар стандарт ашиглаж анхан шатны шүүхийн шийдвэрийг хянахыг заана. Жишээ нь, судалгааны дээрх хэсэгт дурдсанчлан de novo (шинэ байдлаар), abuse of discretion (шүүгчийн буруутай шийдвэрийг шалгах) гэх мэт хяналтын хэлбэрийг бичнэ.

b) Analysis- Тодорхой асуудлуудыг хуулийн үндэслэлээр, нотлох баримт, хэргийн бодит нөхцөлтэй харьцуулан дүгнэж, анхан шатны шийдвэр зөв, хуульд нийцсэн эсэхэд дүгнэлт хийнэ. Энэ хэсэгт шүүх хуралдааны тэмдэглэл, талуудын тайлбар, маргаан үүсгэж буй асуудлуудыг дэлгэрэнгүй тусгадаг.

3. Conclusion – Дүгнэлт

Давж заалдах шатны шүүх анхан шатны шийдвэрийг хэвээр үлдээх эсвэл хүчингүй болгох, тус шийдвэрийн эрх зүйн үндэслэл гэсэн бүтэцтэй байна.

1.2. Хяналтын шатны шүүх

Холбооны Дээд шүүхийн эрх хэмжээнд олон удаагийн өөрчлөлт орсны дараагаар Дээд шүүх бол хөндлөнгийн шүүх буюу анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх (англ. *Original jurisdiction*) болон доод шатны шүүхээс гарсан шийдвэрийг хянах (англ. *Appellate jurisdiction*) эрхийг хамтад нь эдлэх болжээ.⁴

Анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх гэдэгт аливаа улсын элчин сайд, консултай холбогдох хэрэг, муж улсуудын хоорондын маргаанаас үүдэх хэрэг, муж улс бусад улстай холбогдон гарсан хэрэг зэргийг энэ журмаар хянан шийдвэрлэнэ. Доод шатны шүүхээс гарсан шийдвэрийг хянах гэдэгт доод шатны шүүх шийдвэрүүдийг хянахыг ойлгоно.

Холбооны Дээд шүүхийн шийдвэрийн бүтэц⁵

Дээд шатны шүүхийн шийдвэрийн бүтцийг хуульд нарийвчлан заагаагүй. Гэхдээ АНУ-ын Дээд шүүхийн шийдвэр бүрэн ойлгомжтой, хууль хэрэглээний тайлбар агуулсан хэлбэрээр гаргахыг зөвлөдөг байна. Учир нь шүүхийн прецедент нь тус улсын эрх зүйн тогтолцооны чухал бүрэлдэхүүн бөгөөд дээд шүүхийн шийдвэр нь ирээдүйд ижил төрлийн хэргийг хянан шийдвэрлэхэд жишиг, удирдамж болж хууль хэрэглээний нэгдмэл байдал, тогтвортой байдлыг хангах үүргийг гүйцэтгэдэг.

АНУ-ын Дээд шүүхээс эрүүгийн хэргийг хянан хэлэлцсэн шүүхийн шийдвэр нийтлэг дараах бүтэцтэйгээр гардаг байна. Үүнд:

1. Background – Хэргийн түүх, хэргийн нөхцөл байдал

a) Factual History – Хэргийн үйл баримт

b) Legal Background – Холбогдох хууль, тогтоомж, өмнөх нь шийдвэрлэж байсан ижил төсөөтэй жишиг шийдвэрүүдийг дурдаж болно.

c) Procedural History – Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг товч бичнэ.

2. Discussion-Хэлэлцэх асуудал

a) Standard of Review – Шүүхийн хянах аргачлал, шалгуур

⁴ Constitution of the United States(1787), Article III, Section 2-3, <https://constitution.congress.gov/constitution/article-3/>, (Сүүлд үзсэн: 2026.03.13)

⁵ Тус бүмцүүд Barret v. United States, https://www.supremecourt.gov/opinions/25pdf/24-5774_9nbe.pdf, хэргийн шүүхийн шийдвэрийн бүтцээс эш татаж бичсэн болно.



b) Analysis – Хуулийн тайлбар, нотлох баримт, холбогдох жишиг шийдвэрүүдийг дэлгэрэнгүй дурдана.

3. Conclusion- Дүгнэлт

а) Шүүхийн шийдвэр түүний үндэслэл болон хуулийг хэрхэн хэрэглэх талаарх тайлбар, заавар, зөвлөмжийг бичиж болно.

Явцын дүгнэлт: АНУ-ын давж заалдах шатны шүүх нь анхан шатны шүүхийн шийдвэр хуульд нийцсэн эсэх, хуулийг зөв хэрэглэсэн эсэх, хэргийн оролцогчийн хуульд заасан эрхийг зөрчсөн эсэхэд хяналт тавьдаг. Уг хяналтыг тавихдаа үндсэн гурван аргачлалын аль нэгийг ашиглаж болох бөгөөд энэ нь АНУ-ын эрх зүйн тогтолцоонд жишиг болсон практик юм. Дээд шүүх нь тус улсын эрх зүйн тогтолцооны цорын ганц Үндсэн хуульд дурдагдсан шүүх байгууллага бөгөөд тус шүүхээс гарч буй шийдвэр нь ирээдүйд ижил төстэй хэрэгт жишиг болдог.

Шүүхийн шийдвэрийн бүтцийн хувьд аль ч шатны шүүхийн шийдвэрийн бүтэц, хэлбэрийг нарийвчилсан хуулийн зохицуулалтгүй. Гэхдээ тухайн шүүхээс гаргасан дүрэм болон шүүхийн өмнөх жишигт тулгуурлан шүүхийн шийдвэрийг боловсруулдаг. Шүүхийн шийдвэр нь дэлгэрэнгүй, хэргийн оролцогчдод ойлгомжтой байдлаар бичигдсэн байхыг зөвлөдөг. Дээд шүүхийн хувьд шийдвэрийн бүтцэд голлон анхаарах зүйл нь хууль хэрэглээний тайлбар, үндэслэл бөгөөд уг хэсгийг тодорхой, дэлгэрэнгүй бичих ёстой гэж үздэг. Ингэснээр шийдвэр нь жишиг болж, ирээдүйд ижил төстэй хэргийг шийдвэрлэдэг ашиглагдах боломжтой.

2.Бүгд Найрамдах Итали Улс

Бүгд Найрамдах Итали Улс (цаашид "Итали Улс" гэх) нь анхан, давж заалдах болон кассацийн журмаар эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэдэг.

2.1. Давж заалдах шатны шүүх

Давж заалдах шатны шүүх нь анхан шатны шүүхийн ажиллагаа, хууль хэрэглээг хянах чиг үүрэгтэй бөгөөд эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн тогтолцоо нь хоёр төрлийн шүүхээс бүрддэг. Үүнд эрүүгийн хэргийг ердийн журмаар хянан хэлэлцэх (*um.Corte d'Appello*), тангарагтны оролцоотой анхан шатны шүүхийн шийдвэрийг хянан хэлэлцэх (*um.Corte d'Assise d'Appello*) давж заалдах шатны шүүхүүд хамаарна.

Эрүүгийн процессын хуулийн 593 дугаар зүйлд "анхан шатны шүүхийн шийдвэрийг талууд эс зөвшөөрвөл давж заалдах журмаар шүүгдэгч гомдол, прокурор эсэргүүцэл гаргах эрхтэй" гэжээ. Эрүүгийн процессын хуулийн 597 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "зөвхөн шүүгдэгч давж заалдах гомдол гаргасан тохиолдолд давж заалдах шатны шүүх шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулсан шийдвэр гаргахыг хориглоно" гэж заасан. Энэ зохицуулалтыг эрүүгийн процессын эрх зүйд "reformatio in reus" буюу шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулахыг хориглох зарчим⁶ гэж нэрлэдэг байна. Харин прокурор оногдуулсан ял шийтгэлтэй холбогдуулан давж заалдах шатны шүүхэд эсэргүүцэл гаргасан бол шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчилж, шүүгдэгчид оногдуулах ялын төрлийг өөрчлөх, нэмэгдүүлэх эрхтэй

⁶ Massimo Bolognari, "The Appeal in the Italian Criminal Legal System: Legislative Reforms and Case Law" <https://dergiopark.org.tr/en/download/article-file/498175>. 2018, 21.



болно.⁷ Өөрөөр хэлбэл, прокурорын давж заалдах гомдол нь давж заалдах шатны шүүхэд ялыг хүндрүүлэх боломжийг олгодог. Үүнээс бусад тохиолдолд давж заалдах шатны шүүх шүүгдэгчид оногдуулсан ялыг хүндрүүлж, анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчлөх эрхгүй байна.

Итали Улсын эрүүгийн процессын бас нэг онцлог нь давж заалдах шатны шүүх тодорхой нөхцөлд нотлох баримтыг дахин шинжлэх боломжтой байдагт оршино. Тухайлбал, Эрүүгийн процессын хуулийн 603 дугаар зүйлд давж заалдах шатны шүүхээс хэрэгт авагдсан нотлох баримт хангалтгүй гэж үзсэн, шинэ нотлох баримт гарч ирсэн, эсхүл шүүх хэргийн үйл баримтыг тогтооход зайлшгүй шаардлагатай гэж үзсэн тохиолдолд нотлох баримтыг дахин шинжлэх ажиллагаа явуулж болно хэмээн зохицуулсан. Үүний хүрээнд давж заалдах шатны шүүх гэрчийг дахин дуудаж мэдүүлэг авах, шинжээчийн дүгнэлтийг дахин хэлэлцэх зэрэг ажиллагаа явуулах боломжтой.⁸

Эдгээрээс дүгнэхэд, давж заалдах шатны шүүх нь анхан шатны шүүхийн шийдвэрийг зөвхөн хууль хэрэглээг төдийгүй хэргийн үйл баримт, нотлох баримтын үнэлгээг дахин шалгадаг байна. Ийнхүү давж заалдах шатны шүүх тодорхой нөхцөлд нотлох баримтыг дахин шинжлэх ажиллагаа явуулж, хэргийн үйл баримтыг бүрэн тогтоодог байна.

Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн бүтэц

Итали Улсын Үндсэн хууль (1947)⁹-ийн 111 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт "шүүхийн шийдвэр үндэслэлтэй байх бөгөөд шүүх шийдвэрийн үндэслэлээ бичгээр гаргана" хэмээн хуульчилжээ. Шүүгч үндэслэлтэй шүүхийн шийдвэр бичих хэргийн оролцогч талуудад шийдвэрээ тайлбарлаж байгаад тооцогддог байна. Ийнхүү шүүхийн шийдвэрийн үндэслэлийг шийдвэрт тусгаснаар иргэдийн шүүхэд итгэх итгэл нэмэгдэх ач холбогдолтой.

2017 онд Эрүүгийн процессын хуульд томоохон нэмэлт, өөрчлөлт оруулсан. Уг нэмэлт, өөрчлөлтөөр шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсгийг илүү тодорхой, дэлгэрэнгүй тайлбарлах шаардлагыг хуульчилсан бөгөөд энэ нь шүүхийн шийдвэрийн чанар, ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилготой байв. Эрүүгийн процессын хуулийн 546 дугаар зүйлд шүүхийн шийдвэрийн үндэслэлд тусгах агуулгыг нарийвчлан тодорхойлж, шүүх шийдвэр гаргахдаа ямар үйл баримт, эрх зүйн үндэслэлд тулгуурласан, нотлох баримтыг ямар шалгуураар үнэлсэн, эсрэг нотлох баримтыг яагаад няцаасан зэрэг асуудлыг тодорхой тайлбарлах шаардлагатайг заасан. Ингэснээр шүүхийн шийдвэрийн ил тод, ойлгомжтой байдлыг нэмэгдүүлэх, түүнчлэн давж заалдах болон кассацийн шатны шүүхээс шүүхийн шийдвэрт хяналт тавих боломжийг сайжруулсан онцлогтой.

Давж заалдах шатны шүүхийн магадлал бичих аргачлал нь Эрүүгийн процессын хуулийн 546 дугаар зүйлд заасан шүүхийн шийдвэрийн ерөнхий бүтэц дээр үндэслэдэг. Уг зохицуулалтад шүүхийн шийдвэрт шүүхийн нэр, хэрэгт холбогдох этгээдийн мэдээлэл, хэргийн үйл баримт, шүүхийн үндэслэл

⁷ Мөн тэнд, 597.2a

⁸ Massimo Ceresa-Gastaldo, *Fairness in Criminal Appeal, The Evidence Renewal Model in Italy*, <https://link.springer.com/book/10.1007/978-3-031-13001-4>, 2023, 15.

⁹ Costituzione Della Repubblica Italiana, <https://www.normattiva.it/uri-res/N2Ls?urn:nir:stato:costituzione>. (Сүүлд үзсэн: 2026.03.09).



болон эцсийн шийдвэрийг тусгах зэрэг нийтлэг шаардлагуудыг тодорхойлсон бөгөөд давж заалдах шатны шүүхийн магадлал нь мөн энэ бүтэц дээр суурилна.

Шигтгээ 1. Итали Улсын Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалын бүтэц

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалын бүтэц:

Гарчиг (um. Intestazione);

Удиртгал хэсэг: (um. Generalità dell'imputato);

Хэргийн үйл баримт (um. Imputazione);

Яллах дүгнэлтийн агуулга

Өмнөх шатны шүүхийн шийдвэр

Давж заалдах гомдлын агуулга

Үндэслэх хэсэг (um. Motivazione);

Нотлох баримтыг үнэлсэн байдал

Эрх зүйн дүгнэлт

Тогтоох хэсэг (um. Dispositivo);

Гарчиг- Шүүхийн шийдвэрийн эхэнд Бүгд Найрамдах Итали Улс (*um. Repubblica Italiana*), Италийн ард түмний нэрийн өмнөөс (*um. In Nome del Popolo Italiano*) гэсэн гарчгийг бичнэ. Энэ нь шүүх эрх мэдэл нь ард түмнээс эхтэй болохыг илэрхийлдэг байна. Үүний дараа тухайн шийдвэрийг гаргаж буй шүүхийн нэр, танхимыг бичнэ.

Удиртгал хэсэг- Шүүхийн шийдвэр удиртгал хэсэгтэй байх бөгөөд энэ хэсэгт шүүх хуралдаанд оролцсон шүүх бүрэлдэхүүн болох даргалагч шүүгч, бусад шүүгчдийн нэрийг бичнэ. Үүний дараа "Шийдвэр" буюу "*Sentenza*" гэх гарчгийг бичдэг. Энэ хэсэгт хэрэгт холбогдох этгээд, шүүгдэгчийн овог, нэр, төрсөн огноо, оршин суугаа газар зэрэг хувийн мэдээллийг бичнэ. Мөн прокурор, өмгөөлөгчийн нэрийг дурддаг байна. Мөн энд хэргийн бодит нөхцөл байдал болон өмнөх шатны шүүхийн шийдвэрийн агуулгыг тайлбарлана. Тодруулбал, яллах дүгнэлтийн агуулга, анхан шатны шүүх уг хэргийг хэрхэн шийдвэрлэсэн тухай бичнэ. Анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч гомдол гаргасан шүүгдэгч, болон прокурорын гомдлын агуулгыг тусгадаг.

Үндэслэх хэсэг- Италийн эрүүгийн процессын эрх зүйд шүүхийн шийдвэр заавал үндэслэлтэй байх шаардлагатай. Энэ хэсэгт шүүх нотлох баримтыг хэрхэн үнэлсэн, эрх зүйн дүгнэлт хийсэн тухай үндэслэлийг дэлгэрэнгүй тайлбарлана.

Тогтоох хэсэг- Шүүхийн шийдвэрийн албан ёсны дүгнэлт бөгөөд товч, тодорхой бичигддэг хэсэг юм.

Эрүүгийн процессын хуулийн 605 дугаар зүйлд давж заалдах шатны шүүхийн магадлалаар дараах шийдвэрүүд гарна гэж заажээ. Үүнд:

- анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх;
- анхан шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь буюу хэсэгчлэн өөрчлөх;
- анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, шинэ шийдвэр гаргах;



- анхан шатны шүүхийн ажиллагаанд процессын ноцтой зөрчил гарсан гэж үзвэл шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр доод шатны шүүхэд буцаана.

2.2. Хяналтын шатны шүүх

Кассацийн шүүх буюу Итали Улсын Дээд шүүх нь анхан болон давж заалдах шатны шүүх эрүүгийн хуулийг зөв хэрэглэсэн эсэх, эрүүгийн процессын хуулийг ноцтой зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэх чиг үүрэгтэй. Энэ шатанд нотлох баримтыг дахин үнэлэхгүй, зөвхөн хууль хэрэглээ болон процессын алдаа гаргасан эсэхийг шалгадаг бөгөөд кассацийн шүүхийг хяналтын шатны шүүх гэж үздэг.¹⁰

Эрүүгийн процессын хуулийн 606 дугаар зүйлд кассацийн шүүхэд гомдол гаргах шалгуурыг дараах байдлаар тодорхойлжээ:

- Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн;
- Эрүүгийн процессын хуулийг ноцтой зөрчсөн, нотлох баримтыг хуульд заасан журмыг зөрчиж цуглуулсан;
- Шүүхийн шийдвэр үндэслэлгүй, үндэслэлийг хангалттай тайлбарлаагүй, эсхүл логикийн илт зөрчилтэй байх.

Шигтгээ 2. Итали Улсын Эрүүгийн хэргийн кассацийн шүүхийн тогтоолын бүтэц

Хяналтын шатны шүүхийн тогтоолын бүтэц:

Гарчиг (um. Intestazione);
Удиртгал хэсэг (um. Generalità dell'imputato);
Хэргийн үйл баримт (um. Ritenuto in fatto);
Холбогдсон хэргийн тухай
Өмнөх шатны шүүхийн шийдвэрүүд
Гомдлын агуулга
Үндэслэх хэсэг (um. Considerato in diritto);
Хууль хэрэглээний дүгнэлт
Тогтоох хэсэг (um. Per Questi Motivi);

Кассацийн шүүхийн тогтоолын гарчиг болон удиртгал хэсэг нь давж заалдах шатны шүүхийн магадлалтай адил хэлбэрээр бичигдэнэ. Харин үндэслэх хэсэгт кассацийн шүүх нь анхан, давж заалдах шатны шүүхийн шийдвэрүүдэд хийсэн хууль хэрэглээний дүгнэлтээ дэлгэрэнгүй тайлбарладаг.

Эрүүгийн процессын хуулийн 620–623 дугаар зүйлүүдэд Кассацийн шүүхийн тогтоолын тогтоох хэсэгт шүүх эцсийн шийдвэрээ гаргах бөгөөд дараах шийдвэрүүдийг гаргана гэжээ. Үүнд:

- Гомдлыг хэрэгсэхгүй болгох (*um.rigetta*) буюу доод шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээнэ.
- Шийдвэрийг хүчингүй болгох (*um.annulla*) буюу хууль хэрэглээний ноцтой алдаа илэрвэл шүүх өмнөх шатны шийдвэрийг хүчингүй болгоно.

¹⁰ Marco Cecchi, Structure and Dynamics of the Italian Criminal Proceeding Today, https://www.iksi.ac.rs/izdanja/penal_populism_2024.pdf?utm_source= (2024), 78.



о Дахин хэлэлцүүлэхээр буцаах (*um.rinvia*) буюу шийдвэрийг хүчингүй болгож хэргийг дахин хэлэлцүүлэхээр доод шатны шүүхэд буцаадаг.

Явцын дүгнэлт: Итали Улсын эрүүгийн хэргийн шүүхийн тогтолцоо нь анхан, давж заалдах, кассацийн гэсэн гурван шаттай бөгөөд шат бүр тодорхой чиг үүрэгтэйгээр эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэдэг байна. Тус улсын Эрүүгийн процессын хуулийн 546 дугаар зүйлд 2017 оны нэмэлт, өөрчлөлт оруулснаар шүүхийн шийдвэрт гарчиг, хэрэгт холбогдох этгээдийн мэдээлэл, хэргийн үйл баримт, үндэслэх хэсэг, тогтоох хэсэг зэрэг агуулгыг тодорхой дараалалтайгаар тусгах шаардлагыг тогтоосон байна. Мөн шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт нотлох баримтыг хэрхэн үнэлсэн, эсрэг нотлох баримтыг ямар үндэслэлээр няцаасан, эрх зүйн дүгнэлтийг хэрхэн хийсэн зэргийг дэлгэрэнгүй тайлбарлах ёстой бөгөөд ингэснээр шүүхийн шийдвэрийн ил тод, ойлгомжтой байдлыг нэмэгдүүлэх, нотлох баримтын үнэлгээ болон эрх зүйн дүгнэлт хэрхэн хийгдсэнийг тодорхой харуулах ач холбогдолтой байна. Шүүхийн шийдвэрийг тодорхой бүтэц, аргачлалын дагуу үндэслэлтэйгээр бичих шаардлага нь давж заалдах болон кассацийн шатны шүүхийн хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх, улмаар шүүхийн шийдвэрийн хууль ёсны болон шударга байдлыг хангах чухал механизм болдог байна.

3. Бүгд Найрамдах Солонгос Улс

Бүгд Найрамдах Солонгос Улс (цаашид "БНСУ" гэх)-ын шүүхийн тогтолцоог тус улсын Үндсэн хуулийн 5-р бүлэгт ерөнхий байдлаар, Шүүхийн зохион байгуулалтын тухай хуульд нарийвчлан тус тус хуульчилсан. Тодруулбал, Үндсэн хууль (1948)¹¹-ийн 101.1, 101.2 дахь хэсэгт "Улсын дээд шүүх нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх дээд шатны байгууллага мөн, Дээд шүүхийн дэргэд "бүх шатны шүүх" байгуулж болно" гэж заажээ.¹²

Шүүхийн тогтолцооны хувьд Үндсэн хуульд гурван шатлалт тогтолцоог тусгаагүй болов ч Шүүхийн зохион байгуулалтын тухай хууль (1949)¹³-д шүүх нь анхан, давж заалдах, дээд шүүхээс бүрдэнэ хэмээн гурван шатлалт тогтолцоог бэхжүүлсэн байна. Анхан шатны шүүх нь эрүү иргэний хэргийн ердийн шүүх, мэргэшсэн шүүх гэдэгт Патентын шүүх, Гэр бүлийн шүүх, Захиргааны хэргийн шүүх, Дампуурлын шүүхийг хамааруулна хэмээн заажээ.

3.1. Давж заалдах шатны шүүх

Давж заалдах шат гэдэг нь хэргийн аль нэг тал анхан шатны шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж гомдлыг хүлээн авсан тохиолдолд давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэлнэ. Үүнд:

¹¹ 대한민국 헌법

Constitution of Republic of Korea.

<https://www.law.go.kr/lsEfinfoP.do?lsiSeq=61603>

¹² 홍완식, 곽관훈, 김명엽, 김재윤 지음 "법학개론" 제10판, 2023, 480.

Hung Wan Sig, Gwag Gwan Hun, Kim Myeong Yeob, Kim Jae Yun etc. "Introduction to law" 10th edition, 2023, 480.

¹³ 대한민국 법원조직법

Court Organization Act of Republic of Korea.

<https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%EB%B2%95%EC%9B%90%EC%A1%B0%EC%A7%81%EB%B2%95>



о анхан шатны шүүхийн шүүгч дангаараа шийдсэн шийдвэрийг анхан шатны шүүх бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх;

о бүрэлдэхүүнтэй шийдвэрлэсэн хэргийг давж заалдах шатны шүүх шийдвэрлэх ажиллагаа багтана.

Давж заалдах шатны шүүх нь ердийн анхан шатны шүүхийн бүрэлдэхүүнтэй шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, мэргэшсэн шүүхүүдээс гарсан анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэх чиг үүрэгтэй. Давж заалдах шатны шүүх хуралдаан нь 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй явагдана.¹⁴

Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн бүтэц

Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг магадлах аргачлал нь онолын талаас дахин шүүх хуралдаан, урьдчилсан хяналт, шүүх хуралдааны дараах хяналт гэсэн 3 төрөл байдаг гэж тайлбарлажээ.¹⁵ Эдгээрийг дэлгэрүүлэн үзвэл:

Дахин шүүх хуралдаан (сол. **복심**) гэдэг нь анхан шатны шүүх хуралдаан болон шүүхийн шийдвэрийн бүхэлд нь хэрэгсэхгүй болгож хэргийг эхнээс нь дахин хэлэлцэхийг хэлнэ.

Дараалсан хяналт (сол. **속심**) гэдэг нь анхан шатны шүүхийн хянан хэлэлцсэн үр дүнг үргэлжлүүлэх байдлаар шинээр илэрсэн нөхцөл байдал ба нотлох баримтыг шинжлэн судлах замаар хэрэг хянан хэлэлцэх ажиллагааг хэлнэ.

Шүүх хуралдааны дараах хяналт (сол. **사후심**) гэдэг нь давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг зөвхөн хэрэгт авагдсан баримтын хүрээнд анхан шатны шүүхийн шийдвэр үндэслэлтэй эсэхийг хянан хэлэлцэх ажиллагааг хэлнэ.¹⁶ Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд давж заалдах хурал нь дараалсан хяналт болон шүүх хуралдааны дараах хяналтын аргаар явагддаг хэмээн судлаачид тайлбарлажээ.¹⁷

Түүнчлэн ЭХХШТХ-ийн дагуу давж заалдах шатны шүүхээс 3 төрлийн шийдвэр гарна. Үүнд, давж заалдах хүсэлтийг хэрэгсэхгүй болгох, хэргийг анхан шатны шүүхэд буцаах, хэргийг харьяаллын дагуу шийдвэрлүүлэхээр буцаах шийдвэрүүд багтана. Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийн бүтэц, тусгах шаардлагатай агуулгыг ЭХХШТХ-ийн нэг бүлэгт бус өөр өөр бүлэгт ерөнхий байдлаар хуульчилсан байдаг. Мөн тус улсын Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр боловсруулах тухай журамд анхан шатны шүүхийн шийдвэрийг хэрхэн боловсруулах талаар дэлгэрэнгүй зааж өгсөн бөгөөд тус журмын 3-р зүйлд анхан шатны шүүхийн шийдвэрийн агуулгатай зөрчилдөхгүй бол давж заалдах шатны шүүхийн шийдвэр бичихэд мөн адил уг журмыг хэрэглэж болно гэж заасан байна.

¹⁴ 대한민국 법원 "사법부소개:고등법원"

Court of Korea "Introduction to the Judiciary: High Court"

<https://www.scourt.go.kr/judiciary/organization/high/index.html> (2026.03.11확인)

¹⁵ 이주원 "형사소송법" 제6판, 2024, 735.

Lee Ju Won "Criminal procedure" 6th edition, 2024, 735.

¹⁶ Мөн тэнд.

¹⁷ Мөн тэнд.

Шигтгээ 3. БНСУ-ын Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн бүтэц

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалын бүтэц:

Гарчиг (сол. ㅍ 제): Шүүхийн нэр, тэнхимийн нэр.

Удиртгал хэсэг (сол. 형식적 기재사항)

Хэргийн дугаар

Шүүгдэгч, прокурор, өмгөөлөгч, иргэний нэхэмжлэгчийн талаарх мэдээлэл

Анхан шатны шүүхийн шийдвэрийн дугаар

Шийдвэр хүчин төгөлдөр болсон он, сар, өдөр.

Тогтоох хэсэг (сол. 주문):

Ял оногдуулах

Ялаас чөлөөлөх, шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах

Үндэслэх хэсэг (сол. 이유):

Давж заалдах гомдлын агуулга

Давж заалдах шатны дүгнэлт

Хэргийн үйл баримт

Нотлох баримтыг үнэлж, дүгнэсэн байдал

Хууль тогтоомжийн хэрэглээ

Дүгнэлт

Давж заалдах шатны шүүхийн шийдвэр дахин бичих үндэслэл (анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон тохиолдолд)

3.2. Хяналтын шатны шүүх

Хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх гэдэг нь давж заалдах шатны шүүхээс гарсан шийдвэрийг Улсын дээд шүүх хяналтын журмаар шийдвэрлэх ажиллагааг хэлнэ.¹⁸ Хяналтын шатны шүүх дараах үндэслэлээр хэрэг хянан шийдвэрлэнэ:

- Шүүхийн шийдвэрийн үндэслэл болгосон Үндсэн хууль, хууль, захирамж тогтоомжид зөрчил байгаа тохиолдолд;
- Шүүхийн шийдвэр гарсны дараа ялыг хүчингүй болгосон, өөрчилсөн эсвэл өршөөл үзүүлсэн үед;
- Дахин шүүх хуралд оролцох хүсэлт гаргах үндэслэл байгаа үед;
- Цаазаар авах ял, бүх насаар нь хорих ял, 10 ба түүнээс дээш жилийн хорих ял оноосон хэрэгт шийдвэрт нөлөөлөх ноцтой алдаа гарсан, эсвэл ялыг шударга бус гэж үзэх ноцтой шалтгаан байгаа тохиолдолд хяналтын шатны шүүх гомдлыг хүлээн авч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулна.

Хяналтын шатны шүүх зөвхөн дээрх үндэслэлээр гаргасан гомдлын хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах бөгөөд өмнөх шатны шүүхийн

¹⁸ Мөн тэнд.

Хяналтын шатны шүүхийг чиг үүргийн хувьд хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах буюу хууль зүйн дүн шинжилгээ хийх ажиллагаа явуулдаг гэж тайлбарлаж болно. Ингэхдээ, уг хэргийн бодит байдлыг зөв тогтоосон эсэх, гэмт этгээдэд ял оногдуулахдаа ялын хэмжээг зөв тогтоосон эсэх гэх мэт нөхцөл байдлыг хамтад дүгнэх замаар хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангадаг байна.²³ Мөн өөр нэг өвөрмөц зохицуулалт байдаг нь анхан шатны шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргахгүйгээр шууд хяналтын шатны шүүхэд гомдол гаргах зохицуулалт юм. Гэвч энэхүү тохиолдол нь зөвхөн хэргийн талууд анхан шатны шүүх хуулийг буруу хэрэглэсэн гэж санал нэгдсэний үндсэн дээр хяналтын шатны шүүхэд гомдол гаргадаг байна.

23 МӨН ТЭНД. 750.



Шигтгээ 4. БНСУ-ын Эрүүгийн хэргийн дээд шатны шүүхийн шийдвэрийн бүтэц

Дээд шүүхийн шийдвэрийн бүтэц:

Гарчиг (сол. ᠯᠣᠭᠡ): Шүүхийн нэр/Хэргийн дугаар, хэргийн нэр

Шийдвэрлэх зүйл

Хэрэглэгдэх хуулийн заалт

Төсөөтэй дээд шүүхийн шийдвэр

Яллагдагчийн нууцалсан нэр, гомдол гаргасан этгээд, өмгөөлөгч, өмнөх шатны шүүхийн шийдвэрийн дугаар

Тогтоох хэсэг

Үндэслэх хэсэг

Давж заалдах гомдлын үндэслэл

Шийдвэр

Дүгнэлт

Явцын дүгнэлт: БНСУ-д эрүүгийн хэргийн шүүхийн тогтолцоо нь анхан, давж заалдах, хяналтын шатны шүүх буюу гурван шатлалт бүхий байна. Чиг үүргийн хувьд анхан шатны шүүх нь хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх бол давж заалдах шатны шүүх нь анхан шатны шүүхийн шийдвэрт гаргасан гомдлыг хүлээн авч хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэх чиг үүрэгтэй байна. Харин Улсын дээд шүүх нь давж заалдах шатны шүүхийн шийдвэрт гаргасан гомдлыг хүлээн авч хэргийг хяналтын журмаар хянан шийдвэрлэх чиг үүрэгтэй байна. Хяналтын шатны шүүх нь чиг үүргийн хувьд хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, доод шатны шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон хуулийг зөв хэрэглэсэн эсэхэд дүгнэлт хийдэг.

Тус улсад анхан шатны шүүхийн шийдвэрийн агуулгатай зөрчилдөхгүй бол давж заалдах шатны шүүхийн шийдвэр бичихэд мөн адил уг журмыг хэрэглэж болдог. Мөн хяналтын шатны шүүхийн шийдвэрийн бүтцийг хуульд нэг бүрчлэн, тусгайлан заагаагүй бөгөөд практикт тогтсон бүтцийн дагуу шүүхийн шийдвэрийг бичдэг байна.

4. Бүгд Найрамдах Франц Улс

Бүгд Найрамдах Франц Улс (цаашид "Франц Улс" гэх) -ын эрүүгийн шүүхийн тогтолцоо нь дараах шатлалтай байна. Үүнд²⁴

- Tribunal de police – эрүүгийн зөрчил (contravention),
- Tribunal correctionnel – хөнгөн гэмт хэрэг (délit),
- Cour criminelle болон cour d’assises – хүнд гэмт хэрэг (crime)-үүдийг хянан шийдвэрлэдэг.²⁵

Франц Улсад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн шатлал, тэдгээрийн эрх хэмжээ, чиг үүргийг тодорхойлох үндсэн эх сурвалж болох Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Code de procédure pénale, 1958)-д эрүүгийн

²⁴ Premier ministre, Direction de l'information légale et administrative (Premier ministre), Ministère chargé de la justice, 2025. <https://www.service-public.gouv.fr/particuliers/vosdroits/F2189?>

²⁵ Code de procédure pénale, (1958) art 521-1, art 381, art 231. https://www.legifrance.gouv.fr/codes/article_lc/LEGIARTI000024497033



хэргийн шүүхийн эрх хэмжээ, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг тодорхойлж, анхан, давж заалдах болон Кассацийн шатны шүүхүүдийн хяналтын хүрээг ялгаатай байдлаар зохицуулдаг.²⁶

Анхан шатны шүүх нь гэмт хэрэгт холбогдох бодит нөхцөл байдлыг тогтоож, нотлох баримтыг шууд судлах үндсэн чиг үүрэгтэй. Францын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль (цаашид "ЭХХШТХ" гэх)-ийн 427 дугаар зүйлд "шүүх нь нотлох баримтыг өөрийн дотоод итгэл үнэмшилд үндэслэн чөлөөтэй үнэлнэ" гэж заасан байдаг.²⁷ Энэ заалт нь анхан шатны шүүхийн гол үүрэг нь хэргийн үйл баримыг тогтоож, нотлох баримтыг бие даан үнэлэх явдал болохыг илэрхийлдэг байна.

4.1. Давж заалдах шатны шүүх

Анхан шатны шүүхийн шийдвэрийг талууд эс зөвшөөрсөн бүхий л тохиолдолд давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах боломжтой талаар ЭХХШТХ-ийн 496 дугаар зүйлд зохицуулсан байдаг.²⁸ Уг заалтын дагуу анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах журмаар дахин хэлэлцүүлэх боломжтой бөгөөд давж заалдах шатны шүүх нь хэргийн үйл баримтыг зөв тогтоосон эсэх болон хуулийг зөв тайлбарлан хэрэглэсэн эсэх талаар дүгнэлт хийх эрхтэй байдаг.

4.2. Хяналтын шатны шүүх

Кассацийн шүүхийн чиг үүрэг нь дээрх хоёр шатнаас үндсээрээ ялгаатай. Кассацийн шүүхийн Эрүүгийн танхим (Chambre criminelle) нь доод шатны шүүхүүдийн шийдвэрийг зөвхөн хууль хэрэглээний үүднээс хянах үүрэгтэй. Кассацийн шүүхэд гомдол гаргах эрхийн талаар ЭХХШТХ-ийн 567 дугаар зүйлд заажээ.²⁹ Мөн зүйлийн 567-1-1 дүгээр зүйлд Кассацийн шүүх үндэслэлгүй гомдлыг урьдчилсан журмаар хүлээн авахгүй байх боломжтой талаар тусгайлан хуульчилсан.³⁰

Кассацийн шүүхийн шийдвэрийн бүтэц

ЭХХШТХ-ийн 485 дугаар зүйлд³¹ зааснаар шүүхийн аливаа шийдвэр нь үндэслэл (motifs) болон шийдвэрлэх хэсэг (dispositif)-ийг заавал агуулсан байх ёстой.

Шигтгээ 5. БНФУ-ын шүүхийн шийдвэрийн бүтэц

БНФУ-ын шүүхийн шийдвэрийн бүтэц:

Удиртгал хэсэг

Үндэслэл хэсэг

Шийдвэрлэх хэсэг

Үндэслэл хэсэг- Шүүхийн гаргасан шийдвэрийн суурь болдог. Өөрөөр хэлбэл шүүх ямар нотлох баримт, хууль зүйн үндэслэлд тулгуурлан шийдвэр гаргаснаа энэ хэсэгт тайлбарладаг.

²⁶ Code de procédure pénale, Livre Ier, dispositions générales.

²⁷ Code de procédure pénale, art. 427.

²⁸ Code de procédure pénale, art. 496.

²⁹ Code de procédure pénale, art. 567.

³⁰ Code de procédure pénale, art. 567.

³¹ Code de procédure pénale, Article 485,

Шийдвэрлэх хэсэг- Шүүхийн эцсийн шийдлийг илэрхийлдэг бөгөөд үүнд дараах зүйлсийг тусгана. Үүнд:

- Шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон эсэх,
- Оногдуулсан ял шийтгэл,
- Хэрэглэсэн хууль заалтууд,
- иргэний нэхэмжлэлтэй холбоотой шийдвэр.

Дээрх байдлаар бүх шатны шүүхийн шийдвэрт тавигдах шаардлагыг хуульчилж өгчээ.

2014 оноос Кассацийн шүүхийг шинэчлэх ажил эхэлсэн бөгөөд уг шинэчлэлийн нэг хэсэг нь шүүхийн шийдвэрийг илүү ойлгомжтой, ил тод болгох явдал байжээ. Уг шинэчлэх ажлын хүрээнд 2014 онд Кассацийн шүүхийн шинэчлэлийн талаарх судалгааны тайлан нийтлэгдсэн бөгөөд энэ нь шинэчлэлийн ажлын эхний алхам байв. Үүний дараа 2017 оны 04 дүгээр сард дээрх тайланд тулгуурлан шүүхийн шинэчлэлийн үндсэн чиглэлүүдийг тодорхойлсон бөгөөд үүнд шүүхийн шийдвэрийг боловсруулах аргачлалыг илүү боловсронгуй болгох мөн хяналтын журмаар гаргасан гомдлын агуулгаас хамааран ялгаатай байдлаар шийдвэрлэх тогтолцоог хөгжүүлэх зорилгыг тусгажээ.³²

Кассацийн шүүхийн уламжлалт шийдвэрүүдийн бичгийн хэв маяг нь ихэвчлэн урт, нийлмэл өгүүлбэрүүдтэй мөн логик бүтэц нь тодорхой бус байсан. Иймээс 2019 онд Кассацийн шүүхийн шийдвэрийн бүтэц, бичиглэлийн хэлбэрийг шинэчлэх зорилгоор **Шүүхийн шийдвэрийн бүтэц, төсөл боловсруулах удирдамж** (фр. Guide des nouvelles règles relatives à la structure et à la rédaction des arrêts)-ийг баталсан бөгөөд уг шинэчлэлийн үндсэн зорилго нь шүүхийн шийдвэрийг илүү ойлгомжтой болгох, шүүхийн практикийг ил тод болгох, мөн шүүхийн шийдвэрийг унших, судлахад хялбар болгох явдал байв.³³ Уг удирдамжийн хүрээнд шүүхийн шийдвэрийн бичгийн хэлбэрт томоохон өөрчлөлт оруулсан нь шууд бичгийн хэв маягийг нэвтрүүлсэн явдал юм. Өөрөөр хэлбэл шүүхийн дүгнэлтийг илэрхийлэхдээ урт нийлмэл өгүүлбэрээс зайлсхийж, тухайн дүгнэлтийг шууд хэлбэрээр илэрхийлэх зарчмыг баримтлах болсон байна.

Шүүхийн шийдвэрийн бүтэц, төсөл боловсруулах удирдамж

1) Шүүхийн шийдвэрийн бүтцийн төсөл, ерөнхий чиглэл

Уг удирдамжийн "1.1.Ерөнхий чиглэл"-д "Кассацийн шүүхээс баталсан шийдвэрийн бүтэц болон бичгийн хэв маягийн өөрчлөлтүүд нь шүүхийн эрх зүйн дүгнэлт гаргах арга зүйд өөрчлөлт оруулах ёсгүй. Өөрөөр хэлбэл, Кассацийн шийдвэрүүдийн уламжлалт силлогист бүтэц буюу ерөнхий эрх зүйн зарчим (majeure), тухайн хэрэгт хамаарах нөхцөл байдал (mineure), шүүхийн дүгнэлт (conclusion) дарааллаар гарах, Кассацийн шүүхийн онцлогт тохирсон шийдвэр гаргах арга зүй нь шүүхийн шийдвэрийн бүтцийг тодорхойлох үндсэн хүчин зүйл хэвээр байх ёстой" гэж дурджээ.

Хяналтын шатны шүүхийн шийдвэрийг өмнө нь 4 хэсэгт хуваан бичлэг байсан бол уг удирдамжид 3 хэсэгт хуваан бичих саналыг гаргажээ. Тодруулбал,

³² Solenne Hortalà, LLD, La réforme de la rédaction des décisions de la Cour de cassation, La semaine du droit – édition générale – n° 37 – 7 septembre 2020, 1537 <https://publications.ut-capitole.fr>

³³ Cour de Cassation, Quide des nouvelles règles relatives à la structure et à La rédaction des arrêts, 2019, 3. <https://www.courdecassation.fr>

4 хэсэгт хуваагдах шүүхийн шийдвэрийн бүтэц нь:

- I. Хэрэг ба процессын явц (Faits et procédure),
 - II. Кассацийн гомдлын үндэслэлүүд (Moyens du pourvoi),
 - III. Шийдвэрийн үндэслэл (Motifs de l'arrêt),
 - IV. Шийдвэрлэх хэсэг (Dispositif) гэсэн хэсгүүдээс бүрдэж байсан.
- Үүнийг дараах байдлаар 3 хэсэгт бүтэц болгож өөрчилсөн байна:
- I. Хэрэг ба процессын явц
 - II. Гомдлын үндэслэл болон шийдвэрийн үндэслэл
 - III. Шийдвэрлэх хэсэг

Дээрхээс харвал, II ба III хэсгүүдийг нэгтгэх байдлаар шүүхийн шийдвэрийн бүтцийг өөрчилжээ. Өөрчилж буй шалтгаан нь шүүхийн дүгнэлтийн логикийг илүү ойлгомжтой болгох зорилготой байсан. Өмнө нь шүүхийн шийдвэрт гомдлын үндэслэл болон шүүхийн хариу дүгнэлтийг тусгаарлан байрлуулах нь шүүхийн оюун дүгнэлт логикийн уншигдах байдлыг сулруулж болзошгүй байсан.

Хяналтын гомдолд хэд хэдэн үндэслэл дурдсан бол шүүхийн шийдвэрийг дараах байдлаар бичихийг санал болгосон байна. Үүнд:

- Хэргийн үйл баримт ба процесс (Faits et procédure)
- Гомдлын үндэслэлүүдийг хэлэлцэх (Examen des moyens)
- Кассацийн гомдлын **нэгдүгээр үндэслэл**
- Гомдлын үндэслэлийн тайлбар (Énoncé du moyen)
- Шүүхийн хариу дүгнэлт (Réponse de la Cour)
- Кассацийн гомдлын **хоёрдугаар үндэслэл**
- Гомдлын үндэслэлийн тайлбар Шүүхийн хариу дүгнэлт
- Эдгээр үндэслэлээр шүүх: (PAR CES MOTIFS, la Cour ...)

2) Кассацийн гомдлын үндэслэлд тайлбар хийх

Уг удирдамжийн зорилго нь Кассацийн шүүхийн шийдвэрийн бичгийн хэлбэрийн аль болох нэгдмэл байдлыг хангахад чиглэнэ. Кассацийн шүүхийн танхимууд гомдлыг шүүхийн шийдвэрт өөр өөрөөр байдлаар тусгах практик буйг дурдсан байна. Үүнд:

Кассацийн шийдвэрийн тухайд (arrêts de cassation) иргэний танхим Кассацийн гомдлын үндэслэлийг (moyen) шийдвэрт хавсаргах аргыг системтэйгээр хэрэглэдэг бөгөөд түүнийг шийдвэрийн үндсэн хэсэгт давтан бичдэггүй. Зарим судлаачид ийм байдлаар давхар бичихгүй байх нь шүүх гомдлын хүрээнээс давж шийдвэр гаргах боломжтой мэт харагдуулж болзошгүй гэж шүүмжилсэн байдаг. Харин эрүүгийн танхим Кассацийн гомдлын үндэслэлийг ихэвчлэн шийдвэрт бүрэн эхээр нь (in extenso) дахин бичдэггүй, өмгөөлөгчдийн гаргасан санал эсвэл прокурорын дүгнэлтийг эш татах байдлаар, зарим тохиолдолд товч эшлэл (visa) хэлбэрээр дурддаг.

Мөн Кассацийн шүүх гомдолд дурдсан үндэслэлээс өөр үндэслэлээр (motif de pur droit) шийдвэр гаргах боломжтой. Энэ нь талуудын гаргасан үндэслэлээс өөр, цэвэр эрх зүйн шинжтэй үндэслэл юм. Хэрэв шүүх өөрийн санаачилгаар

(moyen relevé d'office) эрх зүйн үндэслэл гаргаж ирсэн бол тухайн үндэслэлийн тайлбар болон хэлэлцүүлгийг "шүүх өөрийн санаачилгаар гаргасан үндэслэл" гэсэн тусгай гарчиг дор оруулна. Ийм байдлаар өөрийн санаачилгаар гаргасан үндэслэл нь талуудын өмнө маргаан болгоогүй асуудал байж болох бөгөөд шүүх уг үндэслэлээр шийдвэр гаргахын өмнө талуудад тайлбар өгөх боломжоор хангахыг шаарддаг байна.

3) Шийдвэрийн бичиглэлийн хэв маяг, стандарт

Удирдамжид "нэг өгүүлбэрийн бүтэц"-ээс татгалзах (*Style direct et abandon de la « phrase unique »*)-ыг саналыг тусгажээ. Шүүхийн шийдвэр тогтоол, захирамж (*arrêt, ordonnance*) хэлбэртэй гарахаас үл хамааран шийдвэрийг шууд бичгийн хэв маягаар (*style direct*) боловсруулах шаардлагатай. Өөрөөр хэлбэл шийдвэрийг олон догол мөрөөр бичих бөгөөд өмнөх уламжлалын дагуу бүх үндэслэлийг нэг урт нийлмэл өгүүлбэрээр бичихгүй байхад анхаарах юм.

Гарчиг ба тодорхойлолтууд (*Chapeau et qualités*)

Шийдвэрийн гарчиг хэсэг (*chapeau*) буюу шүүх бүрэлдэхүүн, оролцогч талууд зэрэг мэдээллийг илэрхийлэх хэсгийг шууд бичгийн хэв маягт нийцүүлэх зорилгоор тодорхой хэмжээнд шинэчилсэн. Гэхдээ өнөөгийн байдлаар гарчиг хэсэгт орж ирдэг зарим уламжлалт мэдээллийг агуулгын хувьд өөрчлөхгүйгээр хэвээр үлдээхээр шийдвэрлэсэн. Учир нь Кассацийн шүүхийн шийдвэрийн хөгжлийг харгалзан үзэхэд эдгээр мэдээллийг зайлшгүй өөрчлөх шаардлага одоогоор байхгүй гэж үзжээ.

Бичгийн стандарт (*Standards de rédaction*)

Хэргийн үйл баримт ба процесс (*Faits et procédure*) хэсэгт тухайн шийдвэрийн талаар Кассацийн шүүх ямар байр суурьтай буйг илэрхийлэхгүй. Иймд шийдвэрийн эхэнд маргаан үүсгэсэн шийдвэрийг тодорхой зааж, Кассацийн шүүх хөндлөнгийн байр сууринаас дүгнэлт хийж байгаа гэдгийг илэрхийлэх ёстой. Хэрэгт хамаарах үйл баримтыг илэрхийлэхдээ ихэвчлэн өнгөрсөн цагийн хэлбэр (*passé composé*) ашиглахыг илүүд үздэг бөгөөд энэ нь одоо цаг (*présent de l'indicatif*)-оос илүү зохимжтой гэж үздэг.

"Гомдлын үндэслэлийг хэлэлцэх" хэсэгт гомдлын үндэслэлийг эшлэл хэлбэрээр оруулж байгаа бол:

- түүнийг хашилт (" ") дотор бичнэ;
- налуу бичиг ашиглахгүй.

Хэрэв нэг гомдлын үндэслэл олон хэсэгтэй (*branches*) бол тэдгээрийг:

- тус бүрд нь дугаарлаж,
- шаардлагатай тохиолдолд өмгөөлөгчийн гаргасан саналыг бичигт байгаа дарааллаас өөр дарааллаар байрлуулж болно.

Гомдлын үндэслэлийн тайлбар (*Énoncé des griefs*)

Төрийн зөвлөл (*Conseil d'État*) болон Кассацийн шүүхэд төлөөлөх эрхтэй өмгөөлөгчид уг тайлбарыг бэлтгэдэг. Шийдвэрт оруулахдаа шаардлагатай тохиолдолд товчлох, засварлах боломжтой бөгөөд энэ нь практикт аль хэдийн хэрэглэгдэж ирсэн арга юм.



Хууль эшлэх (visa)

Кассацийн шүүх шийдвэр гаргахдаа хуулийн заалтыг эш татдаг. Жишээлбэл, "Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 700 дугаар зүйлийг үндэслэн гаргасан шаардлагыг хэрэгсэхгүй болгосугай" гэх байдлаар бичдэг байна.

Хуулийн зүйл, заалтыг эшлэх (citation du texte)

Хуулийн заалтыг эшлэхдээ дараах байдлаар эшлэнэ:

- бүрэн эхээр нь (in extenso)
- хэсэгчлэн эш татах (extrait)
- товч агуулгаар тайлбарлах (énoncé en substance) – хэд хэдэн эрх зүйн эх сурвалжийг нэгтгэн хэрэглэж байгаа тохиолдолд ашиглана.

Аль ч тохиолдолд эш татсан бичвэрийн яг аль хувилбарыг хэрэглэж байгааг тодорхой заах шаардлагатай. Жишээлбэл: "Хууль № 2005-735 (2005 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хууль)-ийн шинэчилсэн найруулгаар өөрчлөгдсөн Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 230 дугаар зүйлийн дагуу ..." гэх зэргээр тусгана.

4) 2023 оны шинэчлэл Өргөтгөсөн үндэслэл бичих аргачлал

Кассацийн шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сайжруулах зорилгоор тус шүүхээс 2023 онд **Өргөтгөсөн үндэслэл бичих аргачлал**³⁴ (Motivation enrichie, guide de rédaction) – ыг гаргажээ. Уг аргачлалд шүүхийн шийдвэрийг үндэслэл бичих арга хэлбэр өөрчлөгдөж байгаа боловч шийдвэрийн үндсэн бүтцийг хэвээр үлдээсэн талаар дурджээ.

Уг аргачлалаар шүүхээс эрх зүйн нийтлэг зарчим, хууль (majeure)-ийг тухайн хэргийн нөхцөл байдалд хэрэглэж буй үндэслэлийг илүү дэлгэрүүлэн тайлбарлах шаардлагатай гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, тухайн эрх зүйн зарчим, хууль нь ямар логик үндэслэлээр хэрэглэгдэж байгааг тодорхой тайлбарлах ёстой гэжээ.

Шүүх шийдвэр гаргахдаа зөвхөн тухайн маргаанд хэрэглэгдэх хуулийн заалтыг эш татан дүгнэлт хийхээс гадна тухайн шийдвэрт хүрэхэд нөлөөлсөн гол нөхцөлүүдийг тодорхой тайлбарлах шаардлагатай байдаг. Өөрөөр хэлбэл, шүүхийн үндэслэл тухайн дүгнэлтэд хүрэхэд ямар баримт, нөхцөл байдал, эрх зүйн үндэслэлүүд нөлөөлснийг логик дарааллаар харуулах ёстой. Энэ нь шүүхийн шийдвэрийн ил тод, ойлгомжтой байдлыг хангахаас гадна шүүхийн шийдвэрийн үндэслэл буюу эрх зүйн дүгнэлт гаргах үйл явцыг тодорхой болгодог.

Өргөтгөсөн үндэслэл бүхий шийдвэрийн онцлог нь шүүх зөвхөн нэг боломжит шийдлийг сонгон хэрэглээд зогсохгүй, тухайн маргаанд боломжтой байсан өөр шийдлүүдийг авч үзэж, яагаад тухайн шийдлийг сонгосон болон бусад боломжит хувилбаруудыг ямар үндэслэлээр няцаасан болохыг тайлбарладагт оршино. Ийнхүү шүүх өөр хувилбаруудыг харьцуулан үнэлж, аль шийдэл нь тухайн хэрэгт илүү нийцэж байгааг тодорхойлсноор шүүхийн шийдвэрийн үндэслэлийг илүү системтэй, логик дараалалтай болгож, шийдвэрийн үндэслэл илүү итгэл үнэмшил төрүүлэхүйц болдог. Үр дүнд нь шүүхийн шийдвэр нь "ямар шийдвэр гаргасан" гэдгийг илэрхийлэхээс гадна "яагаад энэ шийдвэрийг гаргасан" болон

³⁴ Cour de Cassation, Motivation enrichie, guide de rédaction, 2023, https://www.courdecassation.fr/files/files/Demain/Guide_de_r%C3%A9daction_en_motivation_enrichie_sept_2023.pdf



"яагаад өөр шийдлийг сонгоогүй" болохыг тодорхой харуулсан үндэслэлтэй шийдвэр болдог.

Өргөтгөсөн үндэслэл хэрэглэхийг зөвлөдөг тохиолдлууд

Шүүхийн тогтсон практикийг өөрчлөх шийдвэр

Шүүх өмнө тогтсон шүүхийн практик буюу jurisprudence-ийг өөрчилж байгаа бол шийдвэрийн үндэслэлийг илүү дэлгэрэнгүй тайлбарлах шаардлагатай болдог. Учир нь шүүхийн практик өөрчлөгдөх үед өмнөх эрх зүйн тайлбар, шинэ тайлбар хоорондын ялгааг тодорхой тайлбарлах шаардлага бий болдог. Иймээс шүүхийн шинэ байр суурь, түүний эрх зүйн үндэслэл илүү ойлгомжтой байдлаар тайлбарлах ёстой гэж үздэг байна.

Үндсэн эрх зөрчсөн тухай гомдолд хариу өгөх

Кассацийн гомдол нь эрх зүйн үндсэн зарчим, үндсэн эрх зөрчигдсөн тухай бол шүүх өргөтгөсөн үндэслэл хэрэглэхийг зөвлөжээ. Ялангуяа пропорциональ байдлын зарчим хэрэгжих (contrôle de proportionnalité) эсэхийг дүгнэхдээ уг аргачлалыг хэрэглэгддэг. Кассацийн шүүх тухайн хязгаарлалт, тухайн эрх хоорондын тэнцвэрийг тайлбарлах шаардлагатай болдог бөгөөд ийнхүү тайлбарлахдаа өргөтгөсөн тайлбарыг ашигладаг байна.

Бичиглэлийн хэлбэр (*La structure de la motivation enrichie*)

Аргачлалын энэ хэсэгт бичиглэлийн хэв маягт анхаарах зүйлсийг тусгажээ, Тодруулбал, холбоос үгийг хэрхэн ашиглах, ямар холбоос үг ашиглавал илүү үр дүнтэй байх зэргийг дурдсан байна. Мөн түүнчлэн, шүүхийн шийдвэрийг бичихдээ төвийг сахисан, хязгаарлагдмал, даруу хэв маягийг баримтлах шаардлагатай. Ямар ч тохиолдолд шүүхийн шийдвэрийг гаргаж буй шүүгчдийн хувийн үзэл бодол, байр суурь илэрхийлэгдэх ёсгүй, мөн шийдвэрт субъектив байр суурь, эсвэл шүүгчдийн дэмжсэн, буруутгасан, ёжилсон өнгө аяс илэрхийлэх аливаа хэллэг агуулагдах ёсгүй гэжээ.

Мөн найруулга зүй, дүрэм, цэг, таслалын хэрэглээнд онцгой анхаарах шаардлагатай бөгөөд гадаад үг хэллэгийг аль болох хэрэглэхгүй байх тэдгээрийн оронд Франц хэлний тохирох үг хэллэгийг ашиглах нь зүйтэй болохыг дурдсан байна. Шийдвэрийн бичвэрийг уншихад ойлгомжтой байлгахын тулд догол мөрүүд хэт урт байж болохгүй бөгөөд догол мөр нь хагас хуудаснаас уртгүй байвал зохимжтой. Учир нь нэг догол мөр нь шүүхийн үндэслэлийн нэг санааг илэрхийлэх ёстой байдаг байна.

Явцын дүгнэлт: БНФУ-ын Кассацийн шүүхийн шийдвэр нь хуульд заасны дагуу үндэслэл (motifs) болон шийдвэрлэх хэсэг (dispositif)-ээс бүрдэх бөгөөд 2014 оноос эхэлсэн шүүхийн шинэчлэлийн хүрээнд шийдвэрийн бүтэц, бичиглэлийн хэлбэрийг илүү ойлгомжтой, логик дараалалтай болгох зорилгоор өөрчлөлт хийсэн. Энэ шинэчлэлийн нэг чухал хэсэг нь өргөтгөсөн үндэслэл (motivation enrichie) бичих аргачлалыг нэвтрүүлсэн явдал юм.

Өргөтгөсөн үндэслэл нь шүүхийн шийдвэрийн үндэслэлийг илүү тодорхой, системтэй тайлбарлах зорилготой бөгөөд эрх зүйн асуудлыг тодорхойлох, эрх зүйн эх сурвалжийг эш татах, тайлбарын аргачлалыг илэрхийлэх, боломжит өөр шийдлүүдийг харьцуулан үнэлэх зэрэг бүрдүүлэгч элементүүдийг агуулдаг.



Ингэснээр шүүхийн шийдвэр зөвхөн эцсийн дүгнэлтийг илэрхийлэхээс гадна тухайн дүгнэлтэд хүрэхэд нөлөөлсөн нөхцөл байдал, эрх зүйн үндэслэлийг логик дарааллаар тайлбарлах боломжтой болно гэж үзжээ. Ийнхүү Францын Кассацийн шүүхийн шийдвэрийн шинэ бичгийн аргачлал нь шүүхийн шийдвэрийг илүү ойлгомжтой, ил тод болгох, шүүхийн практикийн нэгдмэл байдлыг хангах, мөн шүүхийн эрх зүйн үндэслэлийг илүү тодорхой илэрхийлэхэд чиглэсэн байна.

5. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (цаашид "ХБНГУ" гэх)-д эрүүгийн хэргийн шүүх нь Орон нутгийн шүүх, Муж улсын шүүх, Муж улсын дээд шүүх, Холбооны Улсын дээд шүүх гэсэн 4 шатлалтай. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүхийн шийдвэрт гомдол гаргах журмыг 1950 онд батлагдсан Эрүүгийн процессын хууль³⁵-д тусгасан. Тус улсад давж заалдах журмаар гомдолт гаргахыг *Berufung*, хяналтын журмаар гомдол гаргахыг *Revision* хэмээн ялгаатай байдлаар нэрлэдэг байна.

5.1. Давж заалдах шатны шүүх

ХБНГУ-ын давж заалдах шатны шүүхийг re-trial буюу хэргийг дахин хянан хэлэлцдэг шүүх гэж нэрлэдэг. Давж заалдах журмаар гаргах гомдлыг шүүхийн харьяалал зөрчсөн болон орон нутгийн шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдол гаргадаг. Тус улсад иргэний бүх хэрэгт давж заалдах гомдол гаргаж болдог ч эрүүгийн хэргийн хувьд зөвхөн орон нутгийн шүүхийн шийдвэрт л давж заалдах гомдол гаргана. Харин Муж улсын болон Муж улсын дээд шүүхээс хүнд гэмт хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шийдвэрт давж заалдах гомдол гаргахгүй, шууд хяналтын журмаар гомдол гаргадаг онцлогтой. Муж улсын шүүх болон Муж улсын дээд шүүх нь хүнд гэмт хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэхдээ олон шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэдэг учраас хэргийн үйл баримтыг буруу тогтоох магадлал бага мөн шүүхийн шийдвэрийн үндэслэлийг няхуур гаргах боломжтой гэж үздэг байна.³⁶ Тиймээс Муж улсын болон Муж улсын дээд шүүхийн шийдвэрт давж заалдах журмаар гомдол гаргахгүй, харин шүүх хуулийг зөв хэрэглэсэн эсэхийг хянуулах зорилгоор хяналтын журмаар гомдол гаргадаг.

Дээд шатны шүүхэд доод шатны шүүхийн шийдвэрийг хянуулахаар гомдол гаргахад хэргийн оролцогч талуудад сонгох эрх олгодгоороо тус улсын эрүүгийн эрх зүй онцлогтой бөгөөд уг сонгох эрх нь шүүхийн эрх хэмжээтэй холбоотойгоор бий болжээ. Тодруулбал, шүүгдэгч орон нутгийн шүүх хэргийн үйл баримтыг буруу тогтоосон хэмээн үзвэл хэргийн үйл баримт болон хууль хэрэглээг хянах чиг үүрэг бүхий давж заалдах шатны шүүхэд гомдлоо гаргана. Харин орон нутгийн шүүх нь хэргийн үйл баримтыг зөв тогтоосон ч хуулийг буруу тайлбарлаж хэргийг шийдвэрлэсэн гэж үзвэл давж заалдах шатны шүүхэд гомдол гаргахгүйгээр шууд хяналтын шатны шүүхэд хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй. Үүнийг алгасаж хяналтын гомдол гаргах эрх (rep.Sprungrevision) хэмээн нэрлэдэг байна.

³⁵ Strafprozeßordnung (StPO), <https://www.gesetze-im-internet.de/stpo/index.html>.
(Сүүлд үзсэн: 2026.03.09).

³⁶ Urs Kindhäuser, Kay H. Schumann: *Strafprozessrecht*, 7. überarbeitete Auflage, 2023, S.328.

Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн бүтэц

Хэргийг дахин хэлэлцүүлж шийдвэр гаргаж байгаа тохиолдолд давж заалдах шатны шүүхийн шийдвэр нь ямар бүтэцтэй байх талаар Эрүүгийн процессын хуулийн 328 дугаар зүйл. Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн агуулга хэсэгт ерөнхий байдлаар хуульчилжээ. Тодруулбал, 328 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "давж заалдах гомдол үндэслэлтэй бол шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг хянан шийдвэрлэнэ" гэж заажээ. Уг зүйл, заалтыг тайлбарласан хуулийн тайлбараас харвал давж заалдах шатны шүүхийн шийдвэр нь дараах бүтэцтэй байхаар байна.

Шигтгээ 6. ХБНГУ-ын эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн бүтэц

Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн бүтэц:

1. Удиртгал хэсэг
2. Тогтоох хэсэг
3. Үндэслэх хэсэг

Удиртгал хэсэгт-Тухайн шийдвэрийг гаргаж байгаа шүүхийн нэр, шийдвэрийн дугаар зэргийг дурдана.

Тогтоох хэсэг- Давж заалдах шатны шүүх гомдлыг үндэслэлтэй эсвэл үндэслэлгүй гэж үзсэн талаар дурдана. Гомдол үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон талаар, мөн тухайн хэргийг давж заалдах шатны шүүх хэрхэн шийдвэрлэсэн болон шүүхийн зардлыг хэрхэн хуваарилсан талаар тус тус дурдана. Үүний дараа уг шийдвэрт ашигласан хуулийн заалтыг тусгана.

Үндэслэл хэсэг- анхан шатны шүүхийн шийдвэр болон давж заалдах гомдлын талаар товч дурдана. Үүний дараа шүүгдэгчийн хувийн байдлыг дэлгэрэнгүй бичдэг. Дараагийн цогцолборт анхан шатны шүүхээс хэргийн үйл баримтыг тогтоохдоо ямар алдаа гаргасан талаарх дүгнэлт хэсгийг бичнэ. Мөн анхан шатны шүүхийн хууль хэрэглэхдээ алдаа гаргасан талаар дүгнэлт хийдэг байна.

5.2. Хяналтын шатны шүүх

Хяналтын гомдлыг дараах шүүхийн шийдвэрүүдэд гаргана. Үүнд, Орон нутгийн шүүх, Муж улсын шүүх болон Муж улсын дээд шүүх хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шийдвэрт хуулийг зөв хэрэглэсэн эсэхийг хянуулах эсвэл Муж улсын шүүхээс хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэсэн шийдвэрт хяналтын журмаар тус тус гомдол гаргана.

ХБНГУ-ын Эрүүгийн процессын хуулийн 333 дугаар зүйлээс 358 дугаар зүйлд хяналтын журмаар гомдол гаргах журмын талаар зохицуулсан. Давж заалдах шатны шүүхээс ялгаатай нь хяналтын журмаар гаргасан гомдлоор шүүхийн шийдвэрийг зөвхөн хууль хэрэглээний талаас нь хянадаг. Иймээс хяналтын шатны шүүх хэргийн үйл баримтыг хоёр дахь удаагаа тогтоохгүй мөн шинээр нотлох баримт цуглуулах ажиллагаа явуулдаггүй. Тус улсын эрдэмтэд хяналтын шатны шүүхийн чиг үүрэг нь нэг талаас хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, нөгөө талаас аливаа нэг хэргийг шийдвэрлэх замаар шударга ёсыг



тогтоох явдал хэмээн дүгнэсэн байна.³⁷

Хяналтын шатны шүүхийн шийдвэрийн бүтэц

Хяналтын журмаар гаргасан гомдлыг хяналтын шатны шүүх хүлээн аваад Beschluss болон Urteil гэсэн 2 төрлийн шийдвэр гаргах боломжтой. Эдгээр шийдвэрийн ялгаа болон бүтцийг доорх хэсэгт авч үзэв.

Аман шүүх хуралдааныг явуулахгүйгээр гаргаж буй шийдвэрийг Beschluss хэмээн нэрлэх бөгөөд дараах тохиолдолд уг шийдвэрийг гаргана.

- Хяналтын гомдлыг хүлээн авахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд;
- Эрүүгийн процессын хуулийн 206а дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй нөхцөл байдал үүссэн хэмээн үзэж хэргийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд;
- Шүүгдэгчид ашигтай байдлаар гаргасан хяналтын гомдлыг үндэслэлтэй гэж үзвэл аман шүүх хуралдаан хийхгүйгээр доод шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон тохиолдолд.³⁸

Шигтгээ 7. Холбооны Улсын дээд шүүхийн шийдвэрийн бүтэц

Холбооны Улсын дээд шүүхийн шийдвэрийн бүтэц:

Удиртгал хэсэг (гер. Rubrum)

Тогтоох хэсэг (гер. Tenor)

Шийдвэрийн үндэслэл

Гарын үсэг, өмнөх шатны шүүхийн нэр, шийдвэрийн дугаар.

Удиртгал хэсэг- Шийдвэрийн удиртгал нь Герман Улсын төрийн сүлдний доор шийдвэр (гер. Beschluss) гэсэн гарчигтай байх бөгөөд шүүхийн шийдвэрийн дугаар, шийдвэр гарсан он, сар, өдрийг тэмдэглэнэ. Шийдвэрийн дугаарын тэмдэглэгээнд эрүүгийн хэргийн аль сенат хэргийг шийдвэрлэж байгааг мөн бичдэг байна. Жишээ нь шийдвэрийг 4-р сенат гаргаж байгаа бол шийдвэрийн дугаарыг 4 StR 225/20³⁹ гэх байдлаар бичнэ. Үүнийг дараа тухайн шийдвэрт хуулийн аль заалтыг уг шийдвэрт тайлбарлах гэж байгаа талаар мэдээлэл өгөх зорилгоор тухайн хуулийн заалтыг бичдэг. Жишээ: Эрүүгийн хуулийн тусгай ангийн 315 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтыг тайлбарлах нь (гер „Zur Auslegung der Strafnorm des § 315d Abs. 1 Nr. 3 StGB.“)

Үүний дараа шийдвэрийн дугаар, хэлбэрийг дахин давтаж, аль шүүхийн шийдвэрийг хянах гэж байгааг дурдана. Жишээ: Холбооны дээд шүүхийн 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 4 StR 225/20 шийдвэрээр Штуттгарт мужийн шүүхээс шийдвэрлэсэн хориотой авто тээврийн хэрэгслийн уралдаан явуулсны улмаас хүний амь нас хохироосон гэмт хэргийг хянав. Үүний дараа хэний гаргасан гомдолд үндэслэн шийдвэрлэж байгааг дурддаг байна.

Тогтоох хэсэг- Тогтоох хэсэг нь шүүгдэгч болон хэргийн бусад оролцогчдын хувьд хамгийн чухал хэсэг бөгөөд энэ хэсэгт хяналтын гомдлыг хангасан эсэх,

³⁷ Bernd Heinrich, Tobias Reinbacher: Examinatorium Strafprozessrecht, 4. Auflage, 2024, S.251.

³⁸ § 349 Abs. 4 StPO

³⁹ Холбооны дээд шүүх нь иргэн болон эрүүгийн сенатуудад хуваагдах бөгөөд эрүүгийн хэргийн сенатын шийдвэр нь Араб тоогоор (4 StR 225/20) тэмдэглэгдэх бол иргэний хэргийн сенатаас гаргаж буй шийдвэр нь Ром тоогоор (XII ZB 107/24) тэмдэглэгддэг байна.

тухайн шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг буцаасан эсэх⁴⁰, эсвэл хяналтын шатны шүүх тухайн хэргийг шийдвэрлэж байгаа эсэхийг⁴¹ тодорхой тусгана. Мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг хэн хариуцах талаар дурддаг байна. *Жишээ нь шүүгдэгч Б-ийн 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Штуттгарт мужийн шүүхийн шийдвэрт гаргасан хяналтын гомдлоос татгалзав. Гомдол гаргагч хяналтын гомдол болон хяналтын шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гаргах бусад зардлын хариуцна.*

Шийдвэрийн үндэслэл- Хуульч, эрх зүйчдэд шийдвэрийн хамгийн чухал хэсэг нь шийдвэрийн үндэслэл хэсэг байдаг бөгөөд энэ хэсэгт заавал дагаж мөрдөх бүтэц байхгүй ч практикт тогтсон дараах нийтлэг бүтэц байна.⁴²

1. Өмнөх шатны шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэг болон хяналтын гомдлын талаар товч дурдах

Өмнөх шатны шүүх шүүгдэгчийг Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан аль гэмт хэрэгт гэм буруутай гэж үзсэн, мөн оногдуулсан ял шийтгэл, албадлагын арга хэмжээг товч байдлаар дурдана. Мөн гомдол гаргасан хэргийн оролцогч нь Эрүүгийн процессын хуульд заасан аль үндэслэлээр⁴³ (*Sachrüge* буюу материаллаг хууль зөрчсөн эсвэл *Verfahrenrüge* буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг ноцтой зөрчсөн) гомдол гаргасныг дурдана.

2. Анхан шатны шүүхээр тогтоогдсон хэргийн нөхцөл байдал

„*Nach den Feststellungen*“ үгээр эхлэх энэ хэсэгт анхан шатны шүүхээс тогтоосон хэргийн үйл баримт болон шүүх уг үйл баримтыг хэрхэн дүгнэсэн талаар бичдэг.

3. Хяналтын гомдлыг нягталж үзэх

Энэ хэсэгт өмнөх шатны шүүхийн шийдвэрт гаргасан гомдлыг үндэслэлгүй гэж үзсэн тайлбарыг тусгадаг байна. Жишээ нь шүүгдэгчийн гаргасан гомдол үндэслэлгүй байна гэх өгүүлбэрээр эхлээд яагаад үндэслэлгүй гэж үзсэн талаар дурдана.

4. Шүүхийн шийдвэрийг бүхэлд нь хянах

Хяналтын шатны шүүх нь хяналтын гомдлоос гадна шүүхийн шийдвэр, үйл ажиллагааг бүхэлд нь хянана. Доод шатны шүүхээс шүүгдэгчийг Эрүүгийн хуулийн 315d дугаар зүйлийн 5 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэж дүгнэснийг хяналтын шатны шүүхээс үндэслэлгүй хэмээн дүгнэж шүүгдэгч Эрүүгийн хуулийн 315d дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн №3, 2 дахь хэсэг, 5 дахь хэсэгт заасан гэмт хэргийн үйлдсэн гэж үзсэн талаар эхлээд дурдана.⁴⁴ Үүний дараа тухайн гэмт хэргийг бүрэлдэхүүнээр нь задалж тайлбарладаг байна.

Тухайн гэмт хэргийг тайлбарлахдаа Эрүүгийн хуульд хуульчлах болсон хууль тогтоогчийн зорилгыг, мөн бусад шүүхээс уг гэмт хэргийн бүрэлдэхүүнийг эрүүгийн хэрэг шийдвэрлэхдээ хэрхэн тайлбарласан, мөн эрдэмтдийн бүтээлд

⁴⁰ § 354 Abs. 2 StPO

⁴¹ § 354 Abs. 1, 1a, 1b StPO.

⁴² Dominik Brodowski, Revisionsentscheidungen des Bundesgerichtshofs in Strafsachen – Quellen, Struktur, Analyse, Saarbrücker Rechtszeitschrift, SRZ 2 | 2021, S.110.

⁴³ § 344 Abs. 2 Satz 1 StPO

⁴⁴

хэрхэн тайлбарлаж байгааг иш татаж оруулах замаар тайлбарладаг.

Гарын үсэг, доод шатны шүүхийн шийдвэрийн дугаар- Шийдвэрт шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурна. Гарын үсгийн доор хэргийг шийдвэрлэсэн доод шатны шүүхийн нэр, шийдвэрлэсэн он, сар, өдөр, шийдвэрийн дугаарыг тусгадаг байна.

Аман шүүх хуралдааныг явуулснаар гаргаж буй шийдвэрийг Urteil гэх бөгөөд дараах бүтэцтэй байна.

Шигтгээ 8. Холбооны Улсын дээд шүүхийн шийдвэрийн бүтэц (Urteil)

Холбооны Улсын дээд шүүхийн шийдвэрийн бүтэц:

Удиртгал хэсэг (гер. Rubrum)

Тогтоох хэсэг (гер. Tenor)

Шийдвэрийн үндэслэл

Гарын үсэг, өмнөх шатны шүүхийн нэр, шийдвэрийн дугаар.

Удиртгал хэсэг- "Холбооны Улсын дээд шүүх ард түмний өмнөөс шийдвэр гаргах нь" гэсэн гарчигтай байна. Үүний дараа шийдвэр гаргасан онгоо, шийдвэр гаргаж буй танхимын нэр, шүүх бүрэлдэхүүн болон шүүх хуралдаанд оролцсон талуудын мэдээллийг бичнэ. Үүний дараа хэний гомдлоор, өмнө нь ямар шүүх уг хэргийг шийдвэрлэж байсан талаар дурдана. Мөн хяналтын гомдлыг шүүх хянаад уг гомдол үндэслэлтэй гэж үзсэн эсэх шүүхийн дүгнэлт бичигддэг байна.

Тогтоох хэсэг- Энэ хэсэгт хяналтын гомдлын талаар товч дурдаад уг гомдлыг шүүх хангаж, доод шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон эсвэл хэвээр үлдээсэн талаарх гол дүгнэлтийг бичдэг.

Үндэслэх хэсэг- Үндэслэх хэсгийн цогцолбор бүрийг 1-ээс эхлэн дугаарлана. Үндэслэх хэсэгт өмнөх шатны шүүх тухайн хэргийг хэрхэн шийдвэрлэсэн талаар товч дурдана. Ингэхдээ шүүгдэгчийг эрүүгийн хуулийн тусгай ангид заасан ямар гэмт хэрэг үйлдсэн гэж үзсэн, мөн уг гэмт хэрэгт шүүхээс оногдуулсан ял, албадлагын арга хэмжээний талаар тус тус товч дурддаг. Үүний дараа гомдол гаргасан тал, гомдлын агуулгыг маш товч бичдэг байна.

Үүний дараа Ром тоогоор I гэж дугаарлаад өмнөх шатны шүүхээс тогтоосон хэргийн үйл баримт, оногдуулсан ялын үндэслэл зэргийг дурдана. Ром тоогоор II гэж дугаарласны хойноос хяналтын гомдолд шүүх ямар дүгнэлт өгч байгаа талаар дэлгэрэнгүй дурддаг байна. Өмнөх шатны шүүх тухайн хуулийг хэрхэн буруу тайлбарласан талаар дурдахдаа хууль тайлбарлах аргуудыг ашиглах, мөн дээд шатны шүүхээс тухайн зохицуулалтыг хэрэг шийдвэрлэхдээ хэрхэн тайлбарласан талаар дурдаг. Ийнхүү дурдахдаа хаалтад тухайн шүүхийн шийдвэрийг оруулдаг байна. Мөн тухайн зохицуулалтыг эрдэмтдийн гаргасан хуулийн тайлбар хэрхэн тайлбарласан талаар тусгадаг бөгөөд ингэхдээ хаалтад уг номын зохиогч, номын нэр зэргийг оруулдаг байна.

Явцын дүгнэлт: Тус улсад давж заалдах журмаар гаргах гомдлыг зөвхөн орон нутгийн шүүхийн шийдвэрт гаргадгаараа онцлог байна. Харин Муж улсын шүүх болон Муж улсын дээд шүүх хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлээд гаргасан шийдвэрт давж заалдах журмаар гомдол гаргахгүй шууд хяналтын журмаар гомдол гаргадаг. Мөн давж заалдах шатны шүүх хэргийг хянан

шийдвэрлэхэд шинээр нотлох баримт гаргаж өгөх боломжтой бөгөөд хэргийн үйл баримтыг орон нутгийн шүүх зөв тогтоосон эсэх мөн хуулийг зөв хэрэглэсэн эсэхийг хянадаг. Харин хяналтын шатны шүүх нь доод шатны шүүх хуулийг зөв хэрэглэсэн эсэхийг хянадгаараа ялгаатай байна.

Гомдлыг үндсэн дээр хэргийг хянан шийдвэрлэж байгаа давж заалдах болон хяналтын шатны шүүх нь тухайн гомдлыг аман шүүх хуралдаан хийж шийдвэрлэж байгаа, эсхүл аман шүүх хуралдаан хийхгүйгээр шийдвэрлэж байгаагаас хамааран шүүхийн шийдвэрийн бүтэц ялгаатай байна. Тус улсын эрүүгийн процессын хуульд анхан шатны шүүхийн шийдвэрийг бичих аргачлалын талаар тодорхой хэмжээнд тусгасан ч давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шийдвэрийн бүтцийн талаар нарийвчлан тусгаагүй байна. Давж заалдах шатны шүүх нь хэргийн үйл баримт болон хууль хэрэглээний талаас дүгнэлт хийж байгаа учраас шүүгдэгчийн хувийн байдлыг тодруулсан мэдээллийг шүүхийн шийдвэрт тусгах ёстой гэж үздэг бол хяналтын шатны шүүхийн шийдвэрт энэ талаар тусгахгүй, харин шүүх хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн талаар, мөн тухайн хуулийг яавал зөв тайлбарласан болох талаар түлхүү тусгасан байна.

II. ДҮГНЭЛТ

Эх газрын болон жишгийн эрх зүйн бүлийг төлөөлүүлэн ХБНГУ, БНФУ, БНСУ, Итали Улс болон АНУ-д эрүүгийн хэргийн давж заалдах болон хяналтын шатны шүүхийн эрх хэмжээ, эдгээр шүүхээс гаргаж байгаа магадлал, тогтоолын бүтцийг судлан үзвэл дараах нийтлэг болон ялгаатай тал ажиглагдлаа.

Дээрх улсуудад давж заалдах шатны шүүхийг хэргийн үйл баримт тогтоох болон хуулийг зөв хэрэглэсэн эсэхийг хянадаг шүүх хэмээн үздэг байна. Иймээс хэргийн оролцогч талууд давж заалдах шатны шүүхэд шинээр нотлох баримт гаргаж өгөх боломжтой байна. ХБНГУ-ын хувьд анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн бүх хэрэгт давж заалдах гомдол гаргадаггүй, зөвхөн хөнгөн гэмт хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн орон нутгийн шүүхийн шийдвэрт хэргийн үйл баримт болон хууль хэрэглээг хянуулах зорилгоор уг гомдлыг гаргаж байгаагаараа бусад улсаас ялгаатай байна. Итали Улс болон ХБНГУ-д шүүгдэгчийн эрх зүйн байдлыг хүндрүүлэхийг хориглох зарчим үйлчилдэг учраас дээд шатны шүүхээс доод шатны шүүхийн шийдвэрийг өөрчлөхдөө шүүгдэгчид хохиролтой байдлаар өөрчлөхийг хориглогдог. Уг зарчим нь дээрх улсуудад давж заалдах болон хяналтын шатны шүүхийн аль алинд нь үйлчилдэг байна. Хяналтын шатны шүүхийн хувьд дээрх улсуудад хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг шүүх хэмээн үзсэнээрээ адил байна.

Эх газрын бүлд хамаарах улс орнуудад давж заалдах шатны болон хяналтын шатны шүүхийн шийдвэрийн бүтцийн талаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд ерөнхий байдлаар тусгажээ. Ингэхдээ анхан шатны шүүхийн шийдвэр бичихэд тавигддаг шаардлагыг давах болон хяналтын шатны шүүхэд мөн тавьдаг байна. Тухайлбал, шүүхийн шийдвэр нь үндэслэл бүхий байх ёстой гэсэн шаардлагыг тавьдаг бөгөөд уг шаардлагыг хангаагүй гэж үзвэл дээд шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй талаар зохицуулжээ. Харин БНФУ-ын хувьд 2019 онд Шүүхийн шийдвэрийн бүтэц, төсөл боловсруулах удирдамж, 2023 онд Өргөтгөсөн үндэслэл бичих аргачлалыг тус тус батлан гаргасан байна. Ингэснээр тус улсад шүүхийн шийдвэрийн үндэслэлийг илүү тодорхой,



системтэй тайлбарлах мөн шүүхийн шийдвэр эцсийн дүгнэлтийг илэрхийлэхээс гадна тухайн дүгнэлтэд хүрэхэд нөлөөлсөн нөхцөл байдал, эрх зүйн үндэслэлийг логик дарааллаар тайлбарлах боломж бүрдсэн гэж үздэг байна. Харин жишгийн эрх зүйн бүлд хамаарах АНУ-д эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийн бүтэц, агуулгыг муж тус бүрд харилцан адилгүй хэлбэрээр тогтоодог байна. АНУ-ын Холбооны давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шийдвэр ямар бүтэцтэй байх талаар хуульд нарийвчлан тусгаагүй, шүүхийн дүрэм болон жишиг шийдвэрүүдийн бүтцийг баримталдаг байна.

Дээрх улсуудад шүүхийн шийдвэрийн бүтэц нь удиртгал, тогтоох, үндэслэх гэсэн дарааллаар бичигддэг бол БНФУ-ын хувьд удиртгал, үндэслэх, тогтоох гэсэн дарааллыг баримталж байгаагаараа онцлог байна.



НОМ ЗҮЙ

1. Эрх зүйн эх сурвалж:

1. АНУ-ы Үндсэн хууль 1787 он.
2. АНУ-ын Холбооны хууль 2018 он
3. АНУ-ын Шүүхийн тухай хууль 1789 он.
4. Gerichtsverfassungsgesetz (GVG), 1950.
5. Strafprozeßordnung (StPO), 1950.
6. 대한민국 형사소송법 1954.
7. 대한민국 헌법 1948.
8. 대한민국 법원조직법 1949.
9. 대한민국 대법원 제1부 2025도4422판결.
10. 대한민국 서울고등법원 제13형사부2023노4016판결.
11. Code de procédure pénale, (1958).
12. Code de l'organisation judiciaire, (2006).
13. Cour de cassation, criminelle, Chambre criminelle, 13 février 2019.
14. Cour de cassation, criminelle, Chambre criminelle, 20 février 2019.
15. Cour de cassation, chambre criminelle, 19 mars 2019, pourvoi n°18-81.725.
16. Cour de cassation, criminelle, Chambre criminelle, 10 avril 2019, 18-83.053.
17. Costituzione Della Repubblica Italiana, (1947).
18. Codice Di Procedura Penale, (1988).
19. La Corte d'Appello di Milano, 2048/2024, 04/03/2022.
20. Corte di Cassazione, 22734/2021, 06/09/2021

2. Гадаад хэл дээрх эх сурвалж:**А. Англи хэл дээр**

1. Aleksandar V. Gajić, "Standards of Appellate Review in the International Administration of Criminal Justice", Serbian Political Thought, Vol 13, no1 (2016),
2. Gerard J Kennedy, "The Scope And Standards Of Intermediate Appellate Review", Comparative Procedural Law and Justice, (October 2024), Ch5, 17
3. Edson R. Sunderland, "The Proper Function of an Appellate Court The Proper Function of an Appellate Court", Indiana Law Journal Vol 5, No7 (Apr 1980),
4. J.M. Barendrecht, K.F. Bolt, M.W. de Hoon, "Appeal Procedures: Evaluation and Reform", (2006),
5. Dražan Djukic, "The Right To Appeal In Comparative Perspective", University of Arizona, Vol 19, no 2 (Oct 2018),
6. Aleš Galić, "A Civil Law Perspective On The Supreme Court And Its Functions", 48,
7. Bora Laskin, "The Role and Functions of Final Appellate Courts",



8. Bora Laskin, "The Role and Functions of Final Appellate courts: The Supreme Court of Canada"
9. Marina M. Matic Bošković, "Supreme Court of Justice – Competences and Structure Across Europe", 2023.
10. Marco Cecchi, "Structure and Dynamics of the Italian Criminal Proceeding Today" (2024).
11. Massimo Bolognari, "The Appeal in the Italian Criminal Legal System: Legislative Reforms and Case Law" (2018).
12. Massimo Ceresa-Gastaldo, Fairness in Criminal Appeal, "The Evidence Renewal Model in Italy" (2023).
13. Charles Evans Hughes, The Supreme Court of the United States, 1928 он.
14. Analysis and interpretation of the U.S. Constitution, "Browse the Constitution Annotated",
15. United States Court, About the U.S. Courts of Appeals,
16. United states courts, "About U.S. District Courts"

Б.Герман хэл дээр

1. Bernd Heinrich, Tobias Reinbacher, Examinatorium Strafprozessrecht, 2024.
2. Dominik Brodowski, Revisionsentscheidungen des Bundesgerichtshofs in Strafsachen – Quellen, Struktur, Analyse, Saarbrücker Rechtszeitschrift, SRZ 2 | 2021.
3. Holm Putzke, Jorg Scheinfeld, *Strafprozessrecht*, 2005.
4. Urs Kindhäuser, Kay H. Schumann, *Strafprozessrecht*, 2023.

В. Солонгос хэл дээр

1. 홍완식, 곽관훈, 김명엽, 김재윤 지음 "법학개론" 제10판, 2023.
2. 이주원 "형사소송법" 제6판, 2024
3. 대한민국 법원 "사법부소개:지방법원"
4. 대한민국 법원 "사법부소개:고등법원"

Г. Франц хэл дээр

1. Solenne Hortal, LLD, La réforme de la rédaction des décisions de la Cour de cassation, 2020.
2. Cour de Cassation, Motivation enrichie, guide de rédaction, 2023.
3. Cour de Cassation, Quide des nouvelles règles relatives à la structure et à La rédaction des arrêts 2019.

3. Цахим эх сурвалж:

1. БНФУ-ын Хууль эрх зүй, захиргааны мэдээллийн газрын цахим хуудас, <https://www.service-public.gouv.fr>.
2. БНФУ-ын Хууль, эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://www.legifrance.gouv.fr/>.
3. БНФУ-ын Кассацийн шүүхийн цахим хуудас, <https://www.courdecassation.fr>.



4. Бүгд Найрамдах Солонгос Улсын шүүх эрх мэдлийн нэгдсэн систем: www.scourt.go.kr.
5. Бүгд Найрамдах Солонгос Улсын хууль зүйн нэгдсэн портал: www.law.go.kr.
6. Итали Улсын Эрүүгийн Процессын хуулийн тайлбар, цахим хуудас, www.brocardi.it.
7. Итали Улсын Эрүүгийн Процессын хуулийн тайлбар, цахим хуудас, www.brocardi.it.
8. ХБНГУ-ын эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан: <https://www.gesetze-im-internet.de/aktuell.html>.
9. ХБНГУ-ын шүүхийн шийдвэрийн нэгдсэн сан: <https://dejure.org/gerichte>.